ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Марзатын гудамж 3А, Мөнхбулаг баг,
Есөнзүйл сум, Өвөрхангай аймаг, 62033,
Утас: (976) 9556 3930,
Цахим шуудан: tamgiingazarEzunzuil@gmail.com,
Цахим хуудас: www.Esunzuil.ov.gov.mn

2022.11.08 №01/130

танай _____ -ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ

Тус сумаас Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 56 хуудастай

ДАРГА Ц.БАТ-ӨЛЗИЙ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ХЭМЖЭЭНД ГАРСАН БИЕЛЭЛТИЙН ТОВЧ ТАЙЛАН

/2022 оны байдлаар/

2022.12.28 Мөнхбулаг

Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтуудыг сумын Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, сумын тухайн оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган биелэлтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг Хүний хөгжил, Эдийн засаг, Засаглалын бодлого, Ногоон хөгжил, аялал жуулчлал гэсэн нийт 4 бүлгийн суманд хамаарал бүхий заалтуудын хүрээнд биелэлтийг нь тооцон ажиллаж байна. Хүний хөгжлийн бүлгийн нийт 22 зорилт 54 арга хэмжээнээс 100%-тай биелсэн 19 арга хэмжээ, 90%-тай биелсэн 16 арга хэмжээ, 70%-тай биелсэн 14 арга хэмжээ, 50%-тай биелсэн 2 арга хэмжээ, 30%-тай биелсэн 3 арга хэмжээ байгаад бөгөөд тус бүлэг нь 87,5%-ийн биелэлттэй хэрэгжсэн. Засаглалын бодлого бүлгийн нийт 6 зорилт 22 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 13, 90%-ийн биелэлттэй 9 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 96%-ийн биелэлттэй хэрэгжсэн. Эдийн засаг бүлгийн 8 зорилт 25 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 14 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 5 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 86,3%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна. Ногоон хөгжил, аялал жуулчлал бүлгийн 4 зорилт 8 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд тус бүлэг 88,5%-ийн биелэлттэй хэрэгжсэн байна. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт нийт 40 зорилтийн 109 арга хэмжээ нийт 89,5 хувийн биелэлттэй хэрэгжээд байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс суманд амжилттай хэрэгжиж байгаа зарим онцлог ажлуудыг товч байдлаар авч үзлээ.Үүнд:

Есөнзүйл сумын "Намрын ногоон өдрүүд-2022" үзэсгэлэн худалдаа 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэн худалдаагаар нийт 18 номинацад 40 гаруй иргэн аж ахуй нэгж оролцон шилдгүүдийг шалгарууллаа. Мөн тус үзэсгэлэнд тогтмол оролцдог 5 иргэнийг Засаг дарга 500,000 төгрөгөөр урамшуулан ажиллалаа.

Өвөрхангай аймагт жил бүр зохион байгууллагддаг Цэрэгжилтийн дөл тэмцээнд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11-10 дугаар ангийн 13 хүүхдийн жагсаал, гардан гэсэн үзүүлэх тоглолтыг бэлтгэн 2022 оны 2-р улиралд тэмцээнд оролцож 5-р байранд орсон амжилттай байна. Тус тэмцээний ирж очих унаа болон хоолны зардалд Засаг даргын Тамгын газраас 800000 төгрөгний зардал гараад байна.

Засаг даргын Тамгын газрын хувьд “CALL center” үйлчилгээ буюу түргэн шуурхай утасны үйлчилгээг нэвтрүүлэн иргэдийн өргөдөл гомдол санал асуулга

болон утсаар өгж болох үйлчилгээг цаг тухай бүрт нь өгж ажиллаж байна. Засаг даргын Тамгын газар нь албаны утсыг 2021 оноос эхлэн ажиллуулж 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт албаны утсанд ажил үүрэгтэй холбоотой санал хүсэлт 10 ирээд байгаа бол албан хаагчдид болон байгууллагатай холбоотой өргөдөл гомдол санал одоогоор ирээгүй байна. 2022 оны 10 дугаар сарын байдлаар emongolia цахим системээс нийт 25 иргэнд, 100 гаруй иргэнд хууль эрх зүй болон шүүхийн талаарх мэдээ мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажилласан байна. Мөн хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр нийт 10 гаруй сэдвийн хүрээнд цахим хаягаар мэдээллийг хүргэн 1500 иргэний хандалт аван ажиллаж байна. Мөн 7 сэдвийн хүрээнд гарын авлага боловсруулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар 40кг төл сонгины үр, сормис, байцаа, лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж үрийг авчран өрхүүдэд тараан тариалан дэмжих сангаас усжуулалтын системийг аван ажиллаад байна.

Сумын төв дотор 2,7 км хатуу хучилттай авто зам хийх ажлын зургыг 18,0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийлгээд байна. Мөн 2022 онд сумын төвийн гэрэлтүүлгийн тоо нэмэгдүүлэх үүднээс 18,0 сая төгрөгийн санхүүжилтээр цамхагт гэрлийг хийж ашиглалтад хүлээн авч гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

2022 онд Шинэ ажлын байр 75 бий болсноос түр ажлын байр 42, байнгын ажлын байр 33 бий болсон. Ажил олгогч байгууллага аж ахуйн нэгжид 7 байнгын ажлын байр, иргэдээс ирсэн захиалгын дагуу 14 ажлын байр, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрөөр 10 ажлын байр, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 16 ажлын байр, мод тарих ажилд 15 иргэнийг, төвлөрсөн хогийн цэгийг эмхлэн цэгцлэх хоёрдогч түүхий эд ангилан ялгах нийтийг хамарсан ажилд 13 нийт 75 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангаж ажиллалаа.

Мөнхбулагын 2, Эрээний 4 дүгээр багаас сонгогдсон төлөөлөгчид сайн дурын аян өрнүүлж сумаас өөр аймаг, сумын нутагт оторлож байсан 6 өрх тус бүрт 0,5 тонн нүүрс, хүнсний болон эмний багц нийт 150000 төгрөгийн тусламж хүргэсэн. Сумын Ерөнхий Боловсролын сургуулийн хими биологийн багш Д.Баасанжаргал өөрийн удирдсан ангийн сурагчдыг “Өсвөрийн улаан загалмай”-н бүлэг байгуулан гишүүнээр элсүүлж байнгын хэвтэрийн харж хандах хүнгүй 2 өндөр настанд 2 портёр машин аргал түүж, малчдад хурга, ишигний нэмнээ 30 ширхэг, хурга, ишигний уут 30 ширхэг, бээлий 30 ширхэгийг хийж малчдад мал төллөх үеэр гардуулан өгч дэмжлэг үзүүлсэн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон төлөөлөгчдийн зүгээс санаачлан Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 120 өрхийн хүүхдүүдэд “Эх үрсийн баяр”-ыг тохиолдцуулан бэлэг өгч бяцхан зүрхнүүдийг баярлуулсан. Сумын Улаан Загламайн нийгэмлэгийн салбар хороо 2022 оны эхний 9 сарын байдлаар 900000 төгрөгний татварт оруулж нигүүлсэнгүй үйлсэд хамтран ажиллаж байна.

Тус сургуулийн биеийн тамирын багшийн бэлтгэсэн сурагчид нь аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнээс 2 алт, 2 мөнгө, 4 хүрэл, багаараа эмэгтэй баг 3, эрэгтэй баг 4-р байр, “Ирээдүйн аварга” үндэсний бөхийн барилдаанд 5-6 насны ангиллалд 1 алт, сумо бөхийн аварга аймгийн аварга шалгаруулах уралдаанд 1 сурагч хүрэл медаль авсан бөгөөд Баян-Өндөр суманд зохион байгуулагдсан үндэсний бөхийн барилдаанд нэг сурагч алт, нэг сурагч тусгай байрт, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан үндэсний бөхийн тэмцээнд нэг сурагч тусгай байр, нэг сурагч 5-р байрт тус тус шалгарсан амжилт гаргаад байна.

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН БИЧСЭН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЕСӨНЗҮЙЛ СУМ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

МӨНХБУЛАГ
2022 он

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
/ЕСӨНЗҮЙЛ СУМ/

2022.11.08

Мөнхбулаг

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа болоогүй	30 хувь	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	Арга хэмжээний нэгдсэн хувь
1	Хүний хөгжил	22	54	-	3	2	14	16	19	87,5
2	Эдийн Засаг	8	26	-	-	3	5	3	14	86,3
3	Засаглалын бодлого	6	22	-	-	-	-	9	13	96
4	Ногоон хөгжил, аялал жуулчлал	4	8	-	-	-	2	3	3	88,5
	Нийт	**40**	**109**	**-**	**3**	**5**	**21**	**31**	**49**	**89,5**

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2022.10.03

Есөнзүйл сум

ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2022 он			Хүрсэн үр дүн	Хэрэгжилтийн хувь
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ											
1.1.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ											
Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2	"Цахим соёл", "Соёлын өв-Хөгжлийн дархлаа", "Бүх нийтийн соёлын боловсрол" зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн соёл, урлагийн үйлчилгээнд иргэдийн оролцоо, цахим орчин дахь үндэсний соёлын нөлөөг нэмэгдүүлнэ.	2020 2024	Соёлын төв	30.0 сая Орон нутгийн төсөв	18.0 мян /цахим арга хэмжээнд хамрагдсан хүний тоо/				Соёлын өв хөгжлийн дархлаа" соёлын өвийг бусдад түгээн дэлгэрүүлэх ажилд өөрийн сум орон нутгийн өв болон соёлын өсумын иргэдийн мэдээллийг түгээх ажлыг хийж гүйцэтгэж байгууллагын дотоод ажлуудыг хийж гүйцэтгэсэн. "Соёлын өв хөгжлийн дархлаа" цахим хуудсанд хуваарийн дагуу сум орон нутгийнхаа иргэд, нутаг усныхаа бахархал болсон дурсгалт газар, Ардын авъяастан /Ц.Паламбанди, Э.Оюун, О.Хөгжил, Д.Жамбал, П.Содовсүрэн, П.Батболд.../ өв уламжлагчид /Одхүү, Цэндсүрэн, Усанхүү../ өв тээгчид буюу ЕБС-ийн сурагчидтай хамтран контент бичлэгүүдийг илгээж байсан.	100

										Иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.	
	3	Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж, Эрдэнэзуу, Шанхын хийдийг улсын хамгаалалтад авах ажлыг судалж шийдвэрлэнэ.	2020 2024	Соёлын төв	168.0 Орон нутгийн төсөв	18.0 мянга /Цахим арга хэмжээнд хамрагдсан хүний тоо/				Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн соёл, хууль сахиулах байгууллага, соёлын өвлөн уламжлагч, өв хамгаалагч нарын хамтын ажиллагааг сайжруулах иргэд олон нийтийн өвийн боловсролыг дээшлүүлж соён гэгээрүүлэх “Өв хамгаалагч” аяныг сумын хэмжээнд зохион байгуулж нийт 22 өв хамгаалагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү аяны хүрээнд тэдгээрийн багийн Засаг дарга болон Соёлын төвийн эрхлэгч, гэрээт харуулын үүрэг гүйцэтгэгчийн хооронд хийгддэг гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа	100
Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана.	5	Өлзийт, Баян-Өндөр, Нарийнтээл сумдын Соёлын төвийг засварлан өргөтгөж, Соёлын төвүүдийн тавилга, техник, хэрэгслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, Хайрхандулаан, Есөнзүйл сумдын Соёлын төвийн дотор тохижилт, техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулна.	2020 2024	Соёлын төв	2.0 Тэрбум Улсын төсөв	6 Хөрөнгө оруулалт хийгдсэн байгууллагын тоо				2023 оны аймгийн Засаг Даргын хөтөлбөрт Есөнзүйл сумын Соёлын төвийн их засвар тавигдсан байгаа.Байгууллагын жил бүрийн урсгал засварын зардлаар дотор тохижилт хийгдэж явагддаг.	70
\Зорилт 3. Орон нутгийн соёл, урлагийн үйл	1	Иргэдэд зайны болон нүүдлийн соёл, урлагийн үйлчилгээг	2020 2024	Соёлын төв	68.0 сая Орон Нутгийн	1				Цахим орчинд “Ковид цар тахлын” үеэр хөгжим, дуу, бүжгийн багш нар хүүхдүүд болон насанд хүрэгчдэд	100

ажиллагааны менежментийг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.		хүргэж, зарим сумдын Соёлын төвүүдийг соёлын өв хариуцсан ажилтантай болгоно.			төсөв	Соёлын өвийн ажилтны тоо				дугуйлангийн багш нар цахимаар ажилласан. Мөн алслагдсан бригадын иргэдэд соёл урлагийн явуулын сургалтад зохион байгуулагдсан. Соёлын өвийн ажилтанг гэрээгээр ажиллуулж байна. Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн 56 хүүхдэд цахимаар хүрч үйлчилсэн байгууллагын эдийн засаг цаг хугацааг хэмнэж ажиллаж байна.	
	3	Ном, соёлын үйлчилгээний оновчтой хэлбэрийг бий болгож, орон тоо, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх замаар номын санг цахим болгон хөгжүүлэн, аймгийн Номын сангийн фондод жил бүр 5-аас доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ.	2020 2024	Соёлын төв	20.0 сая Орон Нутгийн төсөв	185 Шинээр нэмэгдэх номын тоо				Номын санд жил бүр 500000 төгрөгний номны баяжилт хийдэг.2022оны хувьд Соёлын яамны хөрөнгө оруулалтаар номын санд ширээ сандлаар бүрэн хангагдсан.Мөн Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газраас шинэ суурин компьютероор хангаж “lifefouryru” программыг суулгах шатанд явагдаж байна. Цахим системтэй болох учир хүүхэд залуучууд болон бүх насныхан цахимаар номоо захиалан унших давуу тал болно.	90
	4	Соёлын өв, урлаг, музейн үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон өргөжүүлж, “Торгоны зам-Хархорум”, “Өндөр Гэгээний соёлын өв уламжлагч” зэрэг соёл, урлаг, уран бүтээл, урлалын цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2020 2024	Соёлын төв	90.0 сая Орон нутгийн төсөв	2 Арга хэмжээний тоо				“ZANABAZAR ART FESTIVAL”- олон улсын фестивалд оролцох олон улсын болон нутгийн урчуудыг таниулах ажилд өөрийн сум орон нутгийн хүрээнд мэдээллийг түгээх ажлыг хийж гүйцэтгэсээр байна. Есөнзүйл сумын Бренд соёлын арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн.	100
Бүлгийн дүн										**93,3%**	
1.2.ЭРҮҮЛ МЭНД											

Зорилт 1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	1	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2021 2024	ЭМТ	1 165.0 сая	Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-25				Төвийн даргын 2022 оны 04 сарын тушаалаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх жагсаалт, болон иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг эрт илрүүлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээх талаар тусламж үйлчилгээний тасралтгүй байдлын хангах журмыг баталсан. Тушаалын хэрэгжилтэнд явцын үнэлгээ хийж ЭМТ-хурлаар хэлэлцүүлж, хэрэгжилтийн явц муу байгаа 11 тусламж үйлчилгээнд холбогдох мэргэжилтнүүдэд хугацаатай үүрэг өгч, эргэн хянасан.	90
	2	Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулна.	2021 2024	ЭМТ	2 238.0	7 хавдрын эрт илрүүлгийн хувь -42.4 АГ- ийн эрт илрүүлгийн хувь 92,0 ЧШ- ийн эрт илрүүлгийн хувь 93.0				Эрүүл мэндийн төвийн Төвийн даргын 2022 оны 04 сарын тушаалаар хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах талаар Амбулатори, яаралтай тусламж, хэвтүүлэн эмчлэх тасаг, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх шаардлагатай журмыг баталсан Амбулатори, өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх хуваарийг эмч, мэргэжилтэн бүрээр 7 хоног бүрээр гаргаж, мөрддөг Хуваарийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлж байгаад тогтмол дотоод хяналт хийж, дүгнэлтийг удирдлагын багт танилцуулж сайн ажилласан мэргэжилтэнд урамшуулал олгодог. Тухайн жилд	90

										хамрагвал зохих зорилтот бүлгийн иргэдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувийг баримтжуулсан 2.Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувийг баримтжуулсан 3.Зохистой түвшинд хянагдаж байгаа хүний тоо/ хувийг баримтжуулсан. 4.Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянадаг 5.Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 6.Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 7.Артерийн даралт ихсэлт өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн	
	3	Иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: -Хүн амын зохистой хоололт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх, давсны хэрэглээг бууруулах арга хэмжээ	2021 2024	ЭМТ	22.0 сая	Илүүдэл жинтэй хүн амын хувь-53.5 Давсны хэрэглээг бууруулсан аж ахуйн нэгжийн тоо-62				Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааны батлагдсан төлөвлөгөөтэй 2.Төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сургалт, сурталчилгааг явуулдаг, тайлантай 3.Сургалтын үр дүнгийн судалгаатай 4.Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, гарын авлагатай, тогтмол баяжуулж, ашигладаг. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгааг аймгийн эрүүл мэндийн газартай хамтран 60 иргэнийг түүврийн аргаар судалгаа	90

										хийхэд амьдралын буруу хэвшилтэй холбоотой дасгал хөдөлгөөний дутагдал , давсны зохисгүй хэрэглээ зэргээс үүдэн цусан холестирины хэмжээ 71,2%-днь ихэссэн байлаа. Судалгааны тайлан дүгнэлтийг эрүүл мэндийн газарлуу илгээсэн. Халдварт бус өвчнийг бууруулах арга хэмжээ “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө”-ний дагуу хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулан даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Хүүхдийн түлэгдэлт - эцэг эхийн хариуцлага-2 сэдэвт Осол гэмтлээс сэргийлэх аяны хүрээнд Цэцэрлэгийн багш нарт осголт хөлдөлт,түлэглэт сэдвээр хичээл заасан нийт 12 багш хамрагдсан.Сургалтаар осголт, хөлдөлт,түлэгдэл гэж юу вэ?анхны тусламж хэрхэн үзүүлэх ариун боолт хэрхэн хийх талаар онол болон дадлагийн хичээл заасан. Сургалтын дараа хүүхдүүдээр цахилгаан хэрэгсэлийн аюултай шинжүүдийг нэрлүүлэн дадлага хийлгэсэн.Нийт 72 хүүхэд хамрууллаа. Гарын авлага 50 ш боловсруулан тараасан. Эцэг эхэд асран хамгаалагчдад бага насны хүүхдийн учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх аюулгүйн ажиллагаа, түлэгдэлт, унаж бэртэх зэрэг ослоос урьдчилан сэргийлэх	

										талаарх зөвлөгөө зөвлөмж тараан эцэг эхийн хариуцлага их өндөр байх ёстойг сурталчилах ажлыг зохион байгуулж ажилласан.Нийт 13 ААН, албан байгууллагад удирдамж тарааж ажилласан.Эрсдэл өндөр айл өрхөөр тойрч мэдээлэл сургалт хийсэн нийт 150 хүнд өгсөн. Халдварт бус өвчин 2021 онд – 952 бүртгэгдэж, 202, онд - 381 бүртгэгдэж буурсан үзүүлэлттэй байна	
	4	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: -Орчны эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ -Сүрьеэ өвчинтэй тэмцэх -БЗХӨ/Дох/Тэмбүү өвчнийг бууруулах арга хэмжээ -Томуу, томуу төст өвчнийг бууруулах арга хэмжээ -“Элэг бүтэн Монгол” арга хэмжээ -Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	2021 2024	ЭМТ	255.0	Эрүүл, аюулгүй, ногоон хот болох төлөвлөгө өний хэрэгжилт ийн хувь-20 Бүх Хэлбэрий н сүрьеэгий н илрүүлэлт ийн хувь-45 Сүрьеэгий ннас баралтын түвшин 3,5				Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн эмч мэргжилтнүүд сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг манай суманд зохион байгууллаа. Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт хүн ам, ялангуяа эрсдэлт бүлгийн иргэд нийт 158 хүн хамрагдлаа үүнээс сүрьеэгийн шижигтэй 18 хүнийг илрүүлж тухайн иргэдээс цэрний шинжилгээ авхад 1 эерэг гарч эмчилгээнд хамрагдууллаа. Энэхүү илрүүлэг шинжилгээтэй хамтатган БЗДХ-ыг илрүүлэх тэмбүү 70, ДОХ/ХДХВ 70 хүнд тус тус хийсэн байна. Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэй ХДХВ/ДОХ-ын шинжилгээ - 9, тэмбүү илрүүлэх шинжилгээ – 9, эрсдэлт бүлгийн иргэдээс ХДХВ/ДОХ-ын шинжилгээ -3, тэмбүү илрүүлэх шинжилгээ – 3	90

										иргэнээс тус тус илрүүлэг үзлэг хийсэн.эдгээрээс бүгд сөрөг гарсан. Сүрьеэ өвчний асуумжиийг 396 хүнээс асуумж судалгаа авч мөн эдгээр иргэдийг халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт хамруулан ажилласан	
	5	Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд: - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ	2021 2024	ЭМТ	270.сая	Эхийн эндэгдлий түвшин 48 5 хүртэлх насны хүүхдийн, Нялхсын эндэгдлий н Түвшин Өсвөр үеийн кабинетий тоо-0 Сэтгэл зүйчийн тоо-0				Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийдэг 2.Эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан, бүртгэл, судалгаатай 3.Хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг Эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийдэг 2.Жирэмслэхээс сэргийлэх аргад сургадаг 3.Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэтэйчүүдийн судалгаатай 4.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээний хувийг баримтжуулсан	90
Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ.	2	Зооноз өвчин судлалын төв, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн болон оношилгооны багажийн чадавхыг дээшлүүлэн, эмчилгээ, сувилгааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	500.0 сая	ЗӨСТ лабораты шинжилгээний тоног төхөөрөмжийн хангалтын хувь-82 сумдын төвүүдийн лаборато				Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны чиглэлээр Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх 16 төрлийн боршурыг сумын цахим орчинд байршуулж энэ төрлийн халдварын үед авах арга хэмжээний сургалтын эмч, эмнэлгийн ажилчдад жилд 12-16 удаагийн дотоод сургалт зохион байгуулсан.	70

	3	Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate систем, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	500.0 сая	ЗӨСТ лаборатын шинжилгээний тоног төхөөрөмжийн хангалтын хувь-82 сумдын төвүүдийн лабораторын оношилгооны хувь-84				Өөрийн харъяаллын 2894 хүн амын бүртгэл, мэдээллийг жил бүр шинэчлэн хөтөлж, баяжилт хийж, эрүүл мэндийн 5 бүлгээр ангилсан.Мэдээллийг тусламж, үйлчилгээний төлөвлөлт, зохион байгуулалтанд ашигладаг Бүртгэл, мэдээлэлтэй холбоотой ЭМС-ын 2019 оны А/611 тушаалын ӨЭ-1 анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлж ажиллаж байна.	90
Зорилт 3. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг хөгжүүлнэ.	1	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийг нэвтрүүлнэ.	2021	ЭМТ	120.0 сая	Мобайл технологийг нэвтрүүлсэн байгууллагын тоо- 2				Мобайл технологийг нэвтрүүлэн Эрүүл мэндийн төвийн Их эмч Б.Баатар хариуцан ажиллаж хэвшээд байна.	90
	2	Оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	2021 2022	ЭМТ	350.0	Оношилго				Оношилгоо, эмчилгээнд алсын зайн мобайл технологийг нэвтрүүлсэнээр хурдан шуурхай мэдээ мэдээлээ авч ажиллаж байна.	90
	3	Жирэмсний нэрийн хяналт, цэргийн үзлэг, эрүүл мэндийн хяналт, бэлгийн замын халдварт өвчний хяналтын программуудыг нэвтрүүлнэ.	2021	ЭМТ	35.0 сая	Энэ төрлийн үйлчилгээнд цахим программ нэвтрүүлсэн тоо				Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэж, эрчимжүүлэлтийн хувь урьд оноос 20-иос доошгүй хувь нэмэгдүүлсэн байна. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 93% ба түүнээс дээш Аймаг, нийслэл, улсын дундаж үзүүлэлттэй харьцуулан үнэлж	90

										дүгнэдэг, сайжруулах арга хэмжээ авсан. Эмч, сувилагч нар нь сургагдсан /эх баригч/. Жирэмсний хяналтыг холбогдох журам, удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг. Жирэмсэн эхийг 100% хяналтанд авсан. Шилжих хөдөлгөөн хийгдсэн жирэмсэн эхчүүдийн бүртгэлтэй Эхчүүдэд жирэмсний хяналтын талаар зөвлөгөө өгч ажиллаж байна.	
	4	Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоог нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	330.0 сая	Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоо-19				Яаралтай тусламжийн багаж, тоног төхөөрөмжийн жагсаалттай, хангасан. Багаж, тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагааг хянадаг Яаралтай тусламжийн нэгжийн тоог нэмэгдүүлсэн. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулах болон аюулгүй ажиллагааны талаар 2 удаагийн сургалт хийж, баримтжуулаад байна.	70
	2	Эмнэлгийн эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг бэлтгэнэ.	2021 2024	ЭМТ	70,0 сая	Эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг тоо-0				Хэвтэн эмчлүүлэх тасагтаа гал тогоотой, гал тогоо нь агуулах, хоол бэлтгэл, хоол хийх гэсэн хэсгүүдээр зөв зохион байгуулагдсан. Хэвтэн эмчлүүлэгчид хооллох тав тухтай орчинг бүрдүүлсэн. Төвийн тогооч нь эмчилгээний хоолны мэргэжилтний сургалтанд хамрагдаж гэрчилгээтэй болоод байна.	100
Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж,	3	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг	2021 2022	ЭМТ		Нийгмийн Асуудалд Дэмжлэг Үзүүлсэн Мэргэжил				Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр. Тус сумын эрүүл мэндийн төв нь магадлангийн хугацаанд нийт 5 их эмч 6 сувилагч, 4 мэргэжилтэн, ажилчид 13 бөгөөд	100

мэргэшүүлэн, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.		дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.			-	й тоо – 5 Орон нутгийн урамшуулын багцад зарцуулсан мэргэжилтний тоо 83				нийт эмч мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ажлын байранд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын сургалтын төлөвлөгөө боловсруулан сар бүр сургалт зохион байгуулж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/566 дугаар тушаал, 274 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын дагуу ижил мэргэжилтний үзлэгийг улирал бүр зохион байгуулж үр дүнг хэлэлцэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Ингэснээр эмч мэргэжилтний мэдлэг ур чадвар сайжирч өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж оношлогоо эмчилгээний чанар хүртээмж сайжирсан. Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр. Хөтөч сувилагчийг орон тоогоор тогтмол ажиллуулж угтан авах, үдэн гаргах үйлчилгээг нэвтрүүлэн амбулаториор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийгкоронавирусын халдвараас урьдчилан сэргийлж биеийн халуун хэмжиж амны хаалт зүүлгэн гар ариутган зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн эмч мэргэжилтнийг харилцаа хандлага ёс зүйн сургалтанд хамруулж ажлын үзүүлэлтэнд нь тусгаж өгсөнөөр үйлчилгээний соел сайжирсан. Мөн хүлээлгийн танхимд иргэдэд хүрэлцэхүйц суух сандал , санал хүсэлтийн хайрцаг, ширээ мэдээллийн самбар гарын авлагууд байрлуулж тусламж үйлчилгээ авах ая тухтай таатай орчин бүрдүүлсэн. Хөгжлийн	

										бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр анхаарч ХБИ- д зориулсан налуу шат, суултуур, шатны бариул, шатнаас халтирч унахаас сэргийлсэн зөөлөвч, суух сандал зэргийг шийдэж ээлтэй орчин бүрдүүлсэн	
	4	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тэдгээрийн мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлнэ.	2021 2024	ЭМТ	1.4 тэрбум	Улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулсан байгууллагын тоо-0				Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулалыг тогтмол ажлыг дүгнэн олгодог. Мөн аймаг болон сум орон нутагт бусад ажилчидаа манлайлан ажилласан эмч, эмнэлгийн ажилчдыг урамшуулж ажиллаж байна.	100
Бүлгийн дүн										**89,2%**	
1.3. Биеийн тамир											
Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	4	Сумдыг нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгож, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	2020 - 2023	ЕБС	123.1	5 Арга зүйч				Есөнзүйл сум нь 2022 оноос эхлэн сумын нийтийн Биеийн тамиоын арга зүйчийг гэрээгээр ажиллуулж байна. Биеийн тамирын арга зүйчийг 500000 төгрөгөөр цалинжуулан Ерөнхий боловсролын сургууль болон бусад албан байгууллагуудтай хамтран биеийн тамирын салбарын үйл ажиллагааны биелэлтийг ханган ажиллаж байна.	100
	5	Биеийн тамирын зориулалтын зам, гадна талбай болон хүүхэд, залуучуудын спорт цогцолбор бий болгож, хөгжлийн	2021 - 2024	ЕБС	2.0 тэрбум	5				440 хүүхдийн суудалтай хуучин сургуулийн гадна талайд байсан биеийн тамирын хэрэгслүүд /турник, тэмээн шат, савлуур/-ийг авчирч шинэ сургуулийн гадна талбайд байрлуулсан бөгөөд шинээр сагсан	70

		бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлэн, нийтийн биеийн тамирын орчныг бүрдүүлнэ.								бөмбөгийн нэг шийдийг нэмж байрлуулсан.	
Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	1	Өсвөрийн шигшээ багийг жудо бөх, чөлөөт бөх, шатар, таеквондо, хүндийн өргөлт, хөнгөн атлетик, цана, волейбол, сагсан бөмбөг, теннисний спортын төрлүүдээр байгуулж, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуульд болон шаардлагатай спортын чиглэлүүдийн дасгалжуулагчийг орон тоогоор ажиллуулна.	2021 - 2024	ЕБС	65.3 сая	- Шигшээ багийн төрөл				Тус сургуулийн биеийн тамирын багшийн бэлтгэсэн сурагчид нь аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнээс 2 алт, 2 мөнгө, 4 хүрэл, багаараа эмэгтэй баг 3, эрэгтэй баг 4-р байр, “Ирээдүйн аварга” үндэсний бөхийн барилдаанд 5-6 насны ангиллалд 1 алт, сумо бөхийн аварга аймгийн аварга шалгаруулах уралдаанд 1 сурагч хүрэл медаль авсан бөгөөд Баян-Өндөр суманд зохион байгуулагдсан үндэсний бөхийн барилдаанд нэг сурагч алт, нэг сурагч тусгай байрт, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан үндэсний бөхийн тэмцээнд нэг сурагч тусгай байр, нэг сурагч 5-р байрт тус тус шалгарсан амжилт гаргасан.	70
Бүлгийн дүн										**80%**	
1.4. Боловсрол											
Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	Шаардлагатай сумдын сургуулиудад спорт тоглоом, хөл бөмбөгийн талбай шинээр барина.	2022 - 2024	ЕБС		-	3			Хөл бөмбөгийн талбай бариулах газрын асуудлыг шийдвэрлүүлсэн.	30
	7	Зарим сумдын сургууль, цэцэрлэгт хөргүүр бүхий мах, ногооны зориулалтын зоорь, агуулах барих, сургууль, цэцэрлэг	2021 - 2024	ЕБС		92.0 сая	4			Тус сургуульд зоорь агуулах баригдаагүй.	30

		орчмын эзэмшлийн талбайн тохижилт, авто машины зогсоол бий болгоно.									
Зорилт 2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ажиллана.	3	Арвайхээр, Хархорин, Богд, Нарийнтээл, Өлзийт, Төгрөг, Бүрд, Хужирт, Есөнзүйл сумдын цэцэрлэгт их засвар, Хужирт сумын 2 дугаар цэцэрлэгт сантехникийн засвар хийнэ.	2021 - 2024	ЕБС		152,8 сая	2			Улсын төсөвийн хөрөнгөөр санхүүжүүлжилтээр сан техник, агаааржуулалтын засварыг хийсэн.Нийт хөрөнгө 61.412.088. Сан техникийн засвар хийсэнээр хүүхдийн сурах хүмүүжүүлэх орчин сайжирсан, агааржуулалт хийгдсэнээр анги танхимын мөөгөнцөр багассан.	100
	4	Төгрөг, Сант, Бат-Өлзий, Өлзийт, Есөнзүйл сумдын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ.	2021 - 2024	ЕБС		112,8 сая	2 дотуур байр			Есөнзүйл сумын ЕБС-ийн 80 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд Өвөрхангай аймгийн ОД ХХК нийт 50 сая төгрөгний өртөгөөр 41 цонх, 13 хаалгыг шинээр сольж цонх, хаалганы амлагааг хийж гүйцэтгэсэн.	70
	5	Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2021 - 2024	ЕБС		200	20 хувь			Захирлын тушаалаар баталсан ажлын хэсэг дотуур байр болон сургуулийн орчны эрсдлийн үнэлгээг хийсэн бөгөөд үнэлгээний дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу орчны эрсдэлийг бууруулах зорилгоор гэрэл цахилгааны монтаж засах, нэмэлт гэрлүүд байрлуулах, хаалганы цоож цуургыг засах, сэлбэх, тавилга эд хогшлыг засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. СӨББ-ийн бүх орчинд эрсдлийн үнэлгээг хийж “Дунд” эрсдэлтэй гэж үнэлээд гарсан зөрчлүүдийг засан сайжруулах арилга чиглэлээр үе шаттай хийж хэрэгжүүлсэн. Гадна	90

										талын хаалганы шат, налуу шатанд халтирахаас сэргийлсэн наалтуудыг наасан, хэрэглэгдэхгүй унжсан утаснуудыг тайрах богиносгох,бүлгүүд тавиур сургалтын хэрэглэгдэхүүний аюулгүй байдлыг хангасан.	
Зорилт 3. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Ерөнхий боловсролын сургуулиудыг шаардлагатай кабинет, лаборатори, цахим тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024	ЕБС		98.7 сая	-	7 сая	7 сая	Хариултын хуудас унших тоног төхөөрөмжийг татан авчирч ашиглаж байна.	70
	2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	ЕБС			6 ширхэг	26,66 1,0	26,66 1,0	Нийт 6 ширхэг суурин ус цэвэршүүлэгчийг татан авчирч бага сургууль болон дотуур байр, 320 хүүхдийн суудалтай шинэ сургуульд байрлуулсан.	70
	7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх, жирийн ангид шилжин суралцах чадварыг дээшлүүлэн, сэргээн засах үйлчилгээг	2021 - 2022	ЕБС		31.9 сая	85 хувь		.	2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн ГБХЗГ, БОЭТ, БСУГ-ын хамтарсан баг хүүхэд хамгаалал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах нөхцөл боломж, эрүүл мэнд, эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт мэдээлэл хийх ажлаар тус сургуульд ажиллаж 5 сурагчийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх хүсэлт гаргасны дагуу 2022 онд сумын эрүүл мэндийн төвийн эмч нар авч явж үзүүлсэн бөгөөд 2 сурагчийг ХБ гэж магадласан. Тус 2 сурагч нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна.	70

		нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.									
Зорилт 4. Сургууль бүрт үйлчилгээний стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоолны хөтөлбөрт хамруулна.	1	.Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	ЕБС		1 тэрбум 220 сая	31	390,374,0	390,374,0	2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд бага ангийн нийт 198 сурагчдад бага сургуулийн гал тогоогоор дамжуулан үдийн хоолоор бүрэн үйлчилж байгаа бөгөөд хоолны цэсийг бага ангийн сургалтын менежер, нярав, тогооч нар хамтран 14 хоног тутамд сольж цэсийн дагуу халуун хоол ундаар үйлчилж байна.	100
	2	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын гал тогоог стандартын шаардлагад нийцүүлэх, засварлах, зориулалтын хөргүүрийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хоол зүйч, хоол үйлдвэрлэлийн технологич орон тоогоор ажиллуулна.	2021 - 2024	ЕБС		53.7 сая	-	12,850,0	12,850,0	320 хүүхдийн суудалтай шинэ хичээлийн байрны гал тогоонд нийт 10ш гал тогооны тоног төхөөрөмж татан авчирч суурилуулсан.	70
	2	Таваас доошгүй хичээл судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиад уралдаан зохион байгуулж, анги хамт олны амжилтыг үнэлж, дүгнэнэ.	2021 - 2024	ЕБС		-	5			2022 оны аймгийн анги нийтийн олимпиад сургуулийн түвшинд 10 дугаар сард, аймгийн хэмжээнд 11 дүгээр сард зохион байгуулагдахаар удирдамж ирсэний дагуу бэлтгэж байна.	30
	8	Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээнд жил бүр амжилтаа ахиулан, сургуулиудыг олон улсын PISA	2021 - 2022	ЕБС		20	-			2022 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд тус сургуулийн бүх багш нар болон түүврээр сонгогдсон сурагчид шалгалдсан бөгөөд тус сургуулийн	50

		үнэлгээнд хамруулж, улсын дундажаас дээгүүр үнэлэгдэх зорилт тавин ажиллана.								үнэлгээ нь улсын дунджаас доогуур, аймгийн дундажаас дээгүүр шалгагдсан.	
Зорилт 6. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх ороно сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн болох зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.	3	Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, бие даан бүтээлчээр суралцахуйд суралцах боломжийг нээн, сургуулийн харьяа уламжлалт өв соёл, хэл, сэтгэн бодох, техник технологи, оюуны спортын төрлийн клуб, төв, дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2024	ЕБС		-	клуб, төв, дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ.			Дугуйлан секц болон хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудад нмэлт элсэлтээ авч үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулСан.	50
Зорилт 8. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	1	Салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулах асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	2021 - 2024	ЕБС		31.0 сая	-	1,4 сая	1,4 сая	2022 оны 10 дугаар сард бүх багш ажилтныг нэмэлт эрүүл мэндийн багц үзлэгүүдэд үзүүлэхээр Өвөрхангай аймгийн Хархорин сумын эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулсан. Бага ангийн багш болон тогооч нарыг аймгийн БЭОТ-тэй хамтран үзлэг шинжилгээнд хамруулсан.	70
	2	Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын	2021 - 2024	ЕБС		-	70 хувь			Өвөрхангай аймгийн багш нарын “Багшийн цахим кампус”, мэргэжлийн багш нарын бүлэг, групп, Aplus цахим сургалтын байгууллага болон БМДИ, БҮТ-үүдээс зохион байгуулсан хуваарьт	70

		70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил, боловсролыг нь дээшлүүлнэ.								болон хуваарьт бус сураглтуудад багш нар амжилттай хамрагдан сорил даалгаврыг гүйцэтгэн мэргэжил боловсролоо дээшлүүлэхийн сацуу заах арга, ур чадвараа түгээн дэлгэрүүлж цахим хичээлүүдийг боловсруулан багшийн цахим кампуст байршуулсан. Мөн бага ангийн математик, 8 дугаар ангийн физик, 11 дүгээр ангийн түүх, 7 дугаар ангийн түүхийн хичээлүүдээр нэгж хичээл боловсруулах medle.mn сайтад байршуулсан.	
Зорилт 9. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.	1	Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2022	ЕБС		10.0 сая	-	3,6 сая	3,6 сая	Тус сургуулийн мэргэжлийн багш, удирдах ажилтнууд Aplus.mn цахим платформоор дамжуулан 3 төрлийн сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн бөгөөд сургалт 10 дугаар сарын 24-нөөс эхэлж 12 дугаар сарын сүүлээр дуусна.	70
	2	Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес, амьдрах ухаан, хүний хөгжил, ёс суртахуун, гоо зүй, гэр бүл, байгаль орчны, иргэний боловсрол (эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах) олгох чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна.		ЕБС		-	18 хувь			2022 онд 8 төрлийн 27 удаагийн давтамжит сургалт үйл ажиллагаагаар нийт 380 хүүхэд, иргэнд хүрсэн. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 320 иргэнд танхимаар, 60 иргэнд онлайн буюу зайнаас хүргэсэн. Дээрх чиглэлийн сургалтаас санхүүгын болон угийн бичиг, мэргэжил сонголт, хувь хүний хөгжил гэх сургалт нь олныг хамарсан сургалт болсон бөгөөд өөрмйн зүгээс урамшуулсан. Харин насанд хүрэгчдийг олноор цуглуулах, малчидад хүрч ажиллахад бэрхшээл гарч байсан.	90
	3	Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт болон ерөнхий	2021	ЕБС		-	-			-Насанд хүрэгчид буюу бичиг үсгийн боловсрол олгох нийт 16 суралцагчидад хоёр удаагийн	90

		боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулна.								давтамжтай зайны сургалт явуулах, түүнд шаардлагатай далгаварын санг мөн хоёр удаа явуулахад шаардлагатай 128000 төгрөгийг сум орон нутгийн удирдлага, багын дарга нарын тусламжтай зохион байгуулсан. Үүнээс дүйцсэн хөтөлбөрийн системд бүртгэлтэй хоёр сурагчийг ерөнхий боловсролын сургуулийн хамт олны тусламжтай анги дэвшүүлсэн. Угийн бичгийн гурван үндсэн чиглэл болох –төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны чиглэл, угийн бичиг хөтлөх уяалдаа холбоог сайжируулах, өрх бүрээр хөтлүүлэх бодлогын үйл ажилгаа, угийн бичгийн ойлголтыг сурагчидад хүргэх гэсэн чиглэлийн дагуу төлөвлөгөө, ажлын хэсэг байгуулж төрийн албан хаагчид, иргэд гэсэн чиглэлийн үйл ажиллагааг хүргээ ажиллалаа.	
	4	Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ.	2021 - 2024	ЕБС		40.0 сая	2			Тус сургуулийн монгол хэл, уранзохиолын багш нар бүх албан байгууллагуудын төрийн албан хаагчдад монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 05-аас 11 дүгээр сарын 05-ны хооронд зохион байгуулахаар дарга, эрхлэгч нартай холбогдож мэдээлэл өгсөн. Мөн тус сумын “Монгол бичгээ дээдлье” группт монгол бичгийн анхан шатны хичээлүүдийг цахимаар заан байршуулсан.	70
Бүлгийн дүн										**70%**	
1.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил											

Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ.	1	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		-	Сургалтад хамрагдсан гэр бүлийн тоо 200 гэр бүл			Гэр бүлийн хүчирхийлэл бол гэмт хэрэг юм гэсэн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар зорилтот бүлгийн иргэдэд 1 удаа сургалтыг хийж мөн боршур тараалаа. Мөн цахимаар гэр бүлийн боловсрол олгох мэдээллийг байршуулан ажиллаж байна. Зорилтот айл өрхүүдээр нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа мэдээ, мэдээллийг өгч ажилласан.	90
	2	Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагыг дэмжин хамтран ажиллана.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		3.0 сая	Зөвлөгөө авсан гэр бүлийн тоо 30 гэр бүл			Багийн иргэдийн нийтийн хуралаар залуу гэр бүл чиглэсэн өрхийн хэрэгцээ, аз жаргалтай гэр бүлийг бий болгох гэсэн сэдвийн хүрээнд танилцууллага бэлдэж залуу гэр бүлд тулгамдсан асуудлыг сонсож уг асуудлыг нэгтгэн Иргэдийн төлөөлөгчдийн хуралын даргад хүргүүлсэн. Аймгийн засаг даргын ивээл дор зохион байгуулж буй "Гэр бүлийн үнэ цэнэ, өнөөгийн байдал" илтгэлийн уралдаанд 19 сумдын иргэд, төрийн албан хаагчдаас Есөн зүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын Б.Цэцэгбадам багш манлайлан оролцож өнөөгийн гэр бүлд тулгарч байгаа олон асуудлыг хөндөж тус илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон. Сумын засаг даргын тамгын газраас дэмжин хамтран ажилласан.	90

	4	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		11,2 сая	Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчийн тоо 8 эмэгтэй 26 хүүхэд			Багш айлчлал үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд гэр бүлийн эрсдэлийг үнэлж, нуугдмал хүчирхийллийг илрүүлэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэр бүл дээр кейс нээж, кейс нээсэн тохиолдлын бүрдүүлэлт хариу үйлчилгээ авах хүрээнд: 2022-2023 оны хичээлийн жилд анги удирдсан багш нар "Багш айчлал" аргачлалын дагуу ангийн сурагчдын эрсдэлийн судалгааг нэгтгэж хамтарсан багаар сумын нэгдсэн судалгааг доорх чиглэлээр гаргасан. • Бүтэн өнчин-3 • Хагас өнчин-49 • Хөгжлийн бэрхшээлтэй-9 • Айлд суудаг-88 • Бие даан амьдардаг-8 • Хурдан морь унадаг-30 • Сургууль завсардсан-4 • Эцэг эхийн хараа хяналт сул-4 • Хойд эцэгтэй-26, Хойд эхтэй-27 нийт дагавар хүүхэдтэй 53 • Тээврийн хэрэгсэл /мотоцикл/ жолооддог 13 сурагч байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд гурван хүүхэд хүлээн авч нөхцөл байдлын үнэлгээ хийн 2022041201 Дугаартай кейс нээж эцэг эхэд гэр бүлийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль танилцуулж, анхан шатны сэтгэл зүйн зөвөлгөө өгч гэр бүлд бүлгийн ярилцлага хийн хамтарсан багаар үйлчилгээ төлөвлөн арга хэмжээг	90

										аван ажиллаж байна. Ар гэрийн гачигдлын улмаас сургууль завсардаж болзошгүй нэг сурагчийг сумын хамтарсан баг, хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллаж тус сурагчийг сургуульд холбон зуучилж, дотуур байранд 2 хүүхдийг авсан. Мөн сумын эрүүл мэндийн газартай хамтран нэг сурагчийг аймгийн БЭОТ-д үзүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй нь батлагдсан. Мөн хүүхдийн тусламж 108 утсанд Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 2 бүртгэгдэн хамтарсан багийн ахлагчид мэдэгдэн хамтарсан багийг хуралдуулж гэр бүл хамгааллын хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.	
Зорилт.3.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ.	1	Залуучуудад бүх чиглэлээр хөгжих орчинг бий болгох зорилгоор “Залуучуудын хөгжлийн төв”-ийг шинээр байгуулан, стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	2021	Нийгми		6.0 сая	Төвөөр үйлчилгээ авбал зохих залуучуудын тоо 12000			Төрөөс баримталж буй бодлогын баримт бичиг дээр үндэслэн Есөнзүйл сумын Залуучууд хөгжлийн зөвлөлийг 21 гишүүнтэйгээр байгуулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаа. Залуучууд хөгжлийн зөвлөл байгуулсан хууль, эрх зүйн үндэслэл. Залуучууд хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгоход дараах төлөөлийг харгалзан үзсэн. Үүнд: төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, өсвөр үе, оюутан, малчин, зорилтод бүлгийн залуучуудын төлөөлийг оруулж тус зөвлөлийг байгуулсан. ЗХЗ-ийн гишүүд YDC.mn сайтаар бүртгүүлж цахим батламж авлаа.	100

										Залуучууд хөгжлийн зөвлөл нь Залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр хөтөлбөр төлөвлөгөөгөө боловсруулан үйл ажиллагаа чанартай зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм. ЗХЗ-ийн дэргэдэх сан үүсгэж байгаа. Уг санг Залуучуудын авъас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, спорт, сургалтын арга хэмжээг зохион байгуулж, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, Залуу малчдыг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг сумын бодлого, төлөвлөгөөнд тусгуулан үр дүнтэй зохион байгуулж ажиллах. Мөн сайн дурын оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Залуучууд өсвөр үеийнхэнд байгаль орчинг хамгаалах, үндэсний өв уламжлалыг өвлүүлэх чиглэлээр төлөвлөгөөндөө тусгаж ажиллах, Залуучуудыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан залуучуудыг соён гэгээрүүлэх, оролцоог нэмэгдүүлэх чиглээр манай зөвлөл маань ажиллах болно. Залуучуудын цахим чуулганд 8 залуучуудыг оролцуулан үзэл бодолоо хуваалцах боломжоор хангалаа.14-35 насны хүмүүсийг залуучууд гэх бөгөөд манай суманд 917 залуучууд	

										байгаагаас 503 эрэгтэй, 414 эмэгтэй залуучууд байна.	
Бүлгийн дүн										**92,5%**	
1.7. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ											
Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.	1	Орон нутгийн нийгэм, эдийн засгийн бодлогод тулгуурлан, салбар бүрт шинээр бий болох ажлын байрыг төлөвлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах замаар 8.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.	2020 - 2024	ХХҮмэргэжилтэн		-	1500 ажлын байр шинээр бий болгоно			Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан төсөл хөтөлбөрийн талаар иргэдэд мэдээлэл өгч ажиллаа. 2 удаа 42 иргэнд хөтөлбөрийн талаар сургалт зохион байгуулсан.Сумын ЗДТГ-ын мэдээллийн самбарт дэлгэрэнгүй мэдээлэл тавьж ажиллаа. Мөн хөтөлбөрийн талаарх мэдээллийг цахим мэдээллийн сувгуудаар иргэдэд хүргэн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ур чадварт үнэлгээ хийн ажиллаж байна Шинэ ажлын байранд 47 иргэнийг бүртгэн түр 34, байнгын ажлын байр 13 бий болгосон. 35 иргэнийг ажлын байранд зуучилсан.	100
	5	Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулан хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2020 - 2024	ХХҮмэргэжилтэн		558,1 сая	700 иргэний төсөл, хөтөлбөрт хамруулсан байна			Малжуулах хөтөлбөрт 2 эмэгтэй, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлийн төсөлд 2 эмэгтэй хамрагдаж ажлын байртай болсон.Мөн албан газар, аж ахуйн нэгж байгууллагад 8 эмэгтэй ажилд зуучлагдан орсон.Мод тарих болон нийтийг хамрсан ажилд 10 эмэгтэй, ямаа самнах ажилд 4 эмэгтэй хамрагдаж түр ажлын байраар хангагдан өрхийн орлогоо нэмэгдүүлж ажилласан.Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрт 1 иргэн хамрагдан ажлын байртай болсон.	100

Зорилт 2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд, ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.	1	Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхижуулна.	2020 - 2024	ХХҮмэргэжилтэн		-	5 удаа			Байгууллага бүр ХАБЭА-н ажилтантай. ХАБЭА-н хүрээнд төрийн байгууллагын мэдээ мэдээлэл, Есөнзүйл сумын зарын нэгдсэн гүппүүдээр зааварчилгаа шторкыг байршуулан ажилласан. Мөн сумын болон албан газруудын ХАБЭА-н ажилтнууд цахимаар 2 удаа сургалтанд хамрагдсан.	100
Зорилт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ	2	Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг, хоршоо байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжин ажиллана.	2020 - 2024	ХХҮмэргэжилтэн		34,5 сая	10 бүлэгт			Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлийн төсөлд 2 ахмад настан хамрагдаж хүлэмжинд хүнсний ногоо тариалж ажлын байртай болсон.Мод тарих болон төвлөрсөн хогийн цэгийг цэгцлэх нийтийгхамарсан ажилд зорилтот бүлгийн 20 иргэн хамрагдсан.	100
	3	"Нэг өрх - Нэг ажлын байр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар нийгмийн халамжийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн тоог бууруулна.	2017 - 2020	ХХҮмэргэжилтэн		193,8 сая	-			"Нэг өрх - Нэг ажлын байр" хөтөлбөрт хамрагдах 12 өрхийг сонгон тэдгээрт нөхцөл байдлын үнэлгээ хийж тоон мэдээллүүдийг аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Хөтөлбөрт хамрагдсан өрхийн 8 иргэн нийтийг хамарсан ажилд хамрагдсан.	100
	4	Нийгмийн халамжид хамрагдахад шаардагддаг материалыг цахимаар хүлээн авч, иргэдэд шуурхай үйлчилнэ.	2020 - 2024	ХХҮмэргэжилтэн		-	16 төрлийн үйлчилгээ			Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч тухай бүрт нь цахим системд бүртгэн ХХҮГазар хүргүүлэн ажиллаж байна. . Тайлангийн	100

										хугацаанд Нийгмийн халамжийн ehalamj.mn программаар 2846 иргэний үйлчилгээг шивж хүүхдийн мөнгө болон тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт үйлчилгээг үзүүлээд байна. Тайлангийн хугацаанд 41 ахмад настан, 67 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт олгосон. Мөн харьяалалгүй 269 ахмад настанд 2 удаа хүндэтгэл үзүүлсэн. 312 ахмад настанд Насны хишгийн тэтгэмжийг олгоод байна.Нийгмийн халамжийг тэтгэврийг 34 иргэнд, асаргааны тэтгэмжийг 112 иргэнд, жирэмсний тэтгэмжийг 48 эхэд, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх/эцгийн/ тэтгэмжийг 149 иргэнд тус тус олгоод байна.	
Зорилт 4. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувираа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.	1	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлж, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.	2020 - 2024	Нийгмийн даатгалын байцаагч			1500			“https://www.facebook.com/esunzuil.daatgal” гэсэн цахим хаяг нээн иргэд даатгуулагчийг урьж одоогоор 320 гишүүнтэй болж өргөжин цахимаар мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цахим эмнэлгийн хуудас болон цахим дэвтрийн талаар мөн нийгмийн даатгалын аппликейшнийг суулгах заавар зөвлөмж өгч, суулгаж өгч ажиллаж байна.	100
	2	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, хувираа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын	2020 - 2024	Нийгмийн даатгалын байцаагч			30065.4			Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасныг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг журам, зааврын дагуу сар бүр хуваарилан төвлөрүүлж ажилласан ба шимтгэлийн орлогын биелэлтийг	100

		хамрагдалтыг нэмэгдүүлнэ.								ханган ажиллаж байна. Оны эхнээс БИНХурлаар 500 орчим иргэдэд мөн 1, 3, 4 дүгээр багийн 164 айл өрхийн 308 малчид иргэдэд 6 удаагийн сургалт, зөвөлгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Сумын малчидын зөвлөгөөнөөр 185 малчинд мэдээлэл хүргэж ажилласан. Энэ жилийн байдлаар давхардсан тоогоор сумын нийт хүн амын 1000 орчим иргэд малчид, даатгуулагчдад мэдээлэл хүргэж ажиллалаа. Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу тус суманд оны эхэнд 6 төсөвт байгууллага, 12 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор шимтгэл төлж байгаа бөгөөд энэ онд 2 ААН шимтгэл төлж одоо нийт 6 төсөвт байгууллага, 14 аж ахуй нэгж байгууллага шимтгэл төлж байна. Иргэд даатгуулагчдад мэдээ мэдээлэл сургалтыг хийснээр даатгуулагдын тоо нэмэгдэж байна.	
Бүлгийн дүн										**100%**	
Бүлгийн дундаж										**87,5%**	

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2022.10.03

Есөнзүйл сум

ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/			Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
							2022 он				
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ											
2.2. Санхүү, төсөв											
Зорилт 1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.	1	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина.	2021 - 2024	САнхүү алба						Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг тухай бүр нь шинэчлэн цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлыг төлөвлөж төрийн албан хаагчдийн цалинг Монгол банкаар дамжуулан олгож эхлэн ажиллаж байна. Хэрэгжилтэнд Сангийн яам, Төрийн сангийн хэлтэс хяналт тавин ажиллаж байна	100
	2	Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж,	2021 - 2024	Санхүү алба						Төсөвт байгууллагууд төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээллийг тогтмол хугацаанд нь байршуулан хяналт тавьж улирал бүр илгээн ажиллаж. Санхүү хяналт дотоод	100

		хариуцлага тооцон ажиллана.								аудит улирал бүр хяналт шалгалт хийж хариуцлага тооцон ажиллаж байна.	
	3	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	САнхүү алба, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн						Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад хүргүүлж, шүүхийн байгууллагад хандсан зээлдэгчийн тоо 2022 оны байдлаар 10 хүний материалыг хүргүүлснээс 1 хүн бүрэн барагдуулж дууссан. өр барагдуулах ажлыг 34.4% хувьд хүргэсэн байна. Авилагатай тэмцэх газраас ирсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлыг тайлагнан холбогдох мэргэжилтэнд албажуулан хүргүүлсэн.	90
	5	Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын давуу эрхийн зөрүү тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.	2021 - 2024	САнхүү алба						Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдах авах тухай хуулийн хүрээнд тендер зарлаж дотоодын аж ахйун нэгж байгууллагатай хамтран ажиллаж байна	100
	6	Цахим тендер шалгаруулалтыг нэмэгдүүлж, цахим системийн хөгжил, шинэчлэлийг ашиглана.	2021 - 2024	САнхүү алба						Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн www.tender.gov.mn цахим хуудасны шинэчлэлийг тогтмол сайжруулан ашиглаж хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.	100
	7	Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч	2021 - 2024	САнхүү алба						Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	90

		байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ.									
Зорилт 2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.	1	Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна.	Жил бүр	Татварын байцаагч						Есөнзүйл сумын Мөнхбулаг 2 дугаар баг, Тахилганы 1 дүгээр баг, Хайрханы 3 дугаар баг, Эрээний 4 дүгээр багийн Иргэдийн нийтийн хурлаар нийт 150 гаруй иргэдэд Малын тоон толгойн аллбан татварын талаарх хууль болон журын талаар танилцуулан мэдээлэл хийж ажиллалаа. Татвар төлөгч иргэн ААН байгууллагуудад Хувь хүний орлогын албан татварын талаарх сургалтын цахим хуудсаар 5 агуулгын хүрээнд 12 удаа бэлтгэн хүргэж ажилласан байна. Мөн Хөдөөний Тахилга 1 баг 30 өрхийн 60 иргэн Хайрханы 3 баг, Эрээн 4 багуудын 25 өрхийн 60 иргэн тойрч иргэдэд Малын тоо толгойн татварын талаар мэдээ мэдээлэл хүргүүлж татварын бүрдүүлэлтийг хурааж ажиллаж байна Хувиараа бизнес эрхлэгч иргэдэд хувь хүний орлогын албан татвар талаар болон татварын тайлан илгээлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөн ажиллаж байна.	90
Зорилт 4: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалын менежментийг сайжруулж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулна.	2021 - 2024	САнхүү алба						Сумын төсөв байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ цаг хугацаанд нь тухай бүр байршуулан улирал болгон мэдээг илгээж ажиллаж байна	100

	5	Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.	2021 - 2024	САнхүү алба						Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэлд тусгах энэ онд улсын үзлэг тооллого зохион байгуулагдаж програмд оруулан нэгтгэж тайлан мэдээтэй тааруулж илгээж тайлагнасан байна. өмч эзэмшигчдийн гэрээг шинэчлэн хариуцуулан ажилласан.	
Бүлгийн дүн										**96,2%**	
2.3. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ											
Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана.	2	Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Сумын хэмжээнд 2022 оны 10 дүгээр сарын 09 өдрийн байдлаар адуу 150 үхэр 200 хонь 1500 ямаа 650 нийт 2500 толгой малыг зах зээлд борлуулсан байна. Мөн зах зээлд 500 толгой малыг борлуулах тал дээр малчтай хамтран ажиллаж байна. Мөн газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуйг Шилмэл сүрэг хоршоо эрхэлж байна Сумын хэмжээнд Хуц 343 Ухна 303 хээлтүүлэгчийг малын үзлэг ангилалтыг үе шаттайгаар явуулж, эзэмэгжүүлж, шинжилгээнд хамруулах ажлыг хувийн мал эмнэлэгийн байгуулагатай хамтран зохион байгуулан эзэмэгжүүлсэн хээлтүүлэгч малын бүртгэл мэдээллийн санд оруулан ажиллалаа.	70
	3	Мал сүргийг бэлчээрийн даацад тулгуурлан сүргийн тоо толгойг зохистой	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Сумын хэмжээнд 2022 оны 10 дүгээр сарын 09 өдрийн байдлаар адуу 150 үхэр 200 хонь 1500 ямаа 650 нийт 2500 толгой малыг зах зээлд борлуулсан	100

		хэмжээнд барьж, чанартай малтай малчдыг урамшуулан, зарим иргэдийг малжуулах төсөлд хамруулан залуу малчдыг бэлтгэж, тэднийг туршлага судлуулах дотоод, гадаадын арга хэмжээнд хамруулна.								байна. Мөн зах зээлд 500 толгой малыг борлуулах тал дээр малчтай хамтран ажиллаж байна. Хөдөлмөрийн хэлтсээс Хайрхан 3-р багийн 2 малчин өрхөд малжуулах төсөлд хамруулсан. Улс, аймаг, сумын аварга малчдын зөвөлгөөнийг сумандаа зохион байгуулан ажиллалаа.	
	4	Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн эрчимжсэн аж ахуйг Шилмэл сүрэг хоршоо эрхэлж байна	50
	5	Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан, түүнийг газар талбай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үр ашигтай ажиллуулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Сумын хэмжээнд өвсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх ажлын орон нутагт үйл ажиллагаа эрхлэдэг Царгаст Хайрхан ХХК, Бест стронг транс ХХК, Дэлгэр Аз хур ХХК нараас 7500 төгрөгөөр ногоон 3000 боодол өвс нөөцлөөд байна. Мөн малчдын түвшинд 1058 тн, өвс 353 гар тэжээл 550 тн, хужир шүү бэлтгэж 83 хувьтай өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган ажлаад байна.	70
	6	"Малын тоо толгойн албан татварын тухай" хуулийн дагуу татварын хувь хэмжээг	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 07 өдрийн 3/01 тогтоолоор малын тоо толгой албан татварыг адуу 1000, үхэр 500,	50

		тогтоохдоо бэлчээрийн даац, малын тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.								хонь 500, тэмээ 500, ямаа 1000 төгрөгөөр тогтоож, малын хөлийн татвар 24 сая төгрөг хураагаад байна	
	9	Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.	2021 - 2024	Хөдөө аж ахуй тасаг						Суманд бод, бог малын хашаатай айл өрх 470, трактор 4, хадуур 272, усны помп 80, GPS 50, монгол гэрийн сөхдөг рам 584 байна. Төрөөс олгож буй ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээлэнд сумын нийт 38 өрхөд 275,100,000 төгрөгний хөнгөлттэй зээл олгогдоод байна.	50
Зорилт 2. Малын халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэж тайван байдлыг хадгалан, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, экспортлох боломжийг бүрдүүлнэ.	1	Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулж, малын эмч болон мал эмнэлгийн нэгжийн тоог нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2020 - 2024	Малын эмч						Тус сумын мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчний вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлэг нь графикийн дагуу биобэлдмэлийг татан авч мал эмнэлэгийн нэгдсэн системд төлөвлөлтийг оруулан Цусах халдвартын вакцинд 2000 үхэр, дуут хавдарын вакцинд 400 үхэр, дотрын халдварт хордлогын вакцинд 22600 хонь, дотрын халдварт хордлого энтеробактериозын хам вакцинд 13600 ямаа, сахуугийн вакцинд 400 унага тус тус хамруулж давхардсан тоогоор 77200 толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 100 хувь хийж гүйцэтгэсэн мөн бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3, 4-р багийн тугал 1500, хурга 31000, ямаа 18000 нийт 50500 толгой төл малд 50500 тун вакциныг 99 хувь, оны боом өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 4-р багийн 30 өрхийн 1000-үхэр , 4 өрхийн 1550 хонь ,	100

										400 -ямаа нийт 2950 толгой малыг 1975 тун, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2-р багийн 16 өрхийн үхэр 480 толгой малыг 480 тун галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 99 хувь тус тус хийж гүйцэтгэсэн болно.мөн Тус суманд мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан үхэр, хонь, ямааг гоц халдварт "Шүлхий" өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын яаралтай төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Чин дөрвөн мэнд" хувийн мал эмнэлгийн малын эмч Б.Баярцэцэг 2022 оны 03 сарын 16 өдрийн А/35 дугаар захирамжаар гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,3, -р багийн үхэр 1635, хонь 23931, ямаа 14799 нийт 40365 толгой малд 42000 тун вакциныг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Засаг даргын 2022 оны 04 сарын 18 ны өдрийн А/53 дугаар захирамжын дагуу 1,2,3,4-р багийн үхэрт гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 2022 оны 04-р сарын 18-нээс 05-р сарын 07 ны хооронд 2 малын их эмч, 4 багийн дарга, 6 туслах ажилтан нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн.1,2,3,4,-р багийн 4400 үхэрийг 100% вакцинд хамруулав. 2022 оны 9 сарын 15 наас засаг даргын А/112 Захирамжын дагуу ажлыг хэсэг томилогдон 3 ажлын хэсэг гарч үхэр сүрэгт шүлхийн вакцин хийгдэж байна. Ажлын явц 86%тай үргэлжилж байна.	

	2	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр бүх сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулна.	2021 - 2022	Малын эмч						Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг 100% цахимжуулан ажиллаж байна.	100
	3	Мал сүрэгт түүврийн аргаар шинжилгээ хийж, түүний дүнг үндэслэн тухайн бүс нутгийг мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болохыг баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдүүлнэ.	2020 - 2024	Малын эмч						2022 оны 3 сард санамсаргүй сонголтын аргаар Есөнзүйл сумын 3 малчин өрх сонгогдон шүлхий өвчний тандалтийг улсын төв лабораторой хамтарсан шинэлгээг аймгийн мал эмнэлэгийн газараас хийсэн үр дүнд өвчин илрээгүй, 6 сард шүлхий вакцины мониторнг санамсаргүй түүвэр аргаар сонгогдсон 1-р багийн малчин С.Болормаа,Н Цэгмид, 4-р багийн малчин П.Отгонбаяр нар сонгогдон үр дүн сайн гарсан. 8 сард хуц, ухна 520, 20 үхэрийн цусны ийлдсийг аймгийн мал эмнэлгийн газарт бруцеллёзын шинжилгээнд хамруулхаар явуудсан. Үхэрийн сүрьелүүр 60 үхэр, ямлуур-60 адуунд сорьл тавихад үр дүн сайн эерэг урвал үзүүлээгүй. Сумын төвийн 4 өрхийн 14 үнээний сүүнд бруцеллёз өвчний шинжилгээ хийхэд 13 үнээ сөрөг, 1 үнээний сүү эерэг урвал үзүүлсэн байна. Эерэг урвал үзүүлсэн үнээний эзэнтэй уулзан зөвөлгөө өгч ажиллаа мөн 2 өрхийн 10 үнээний баасанд өндөг хөвүүлэх шинжилгээ хийн арга хэмжээ авч ажилсан.	100

	4	Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, эмийн үнэд хяналт тавина.	2020 - 2024	Малын эмч						Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх мэдээллийг Есөнзүйл сумын мал эмнэлэнийн тасгийн цахим хуудас, малчиддтай уулзах малчидын зөвөлгөөн дээр малчидад мэдээ мэдээллэр өгч ажиллаа. эмийн үнэд тогтмол хяналт тавин ажиллаа.	100
	5	Мал эмнэлгийн газрын лабораторийг мах, сүүнд шинжилгээ хийдэг /эм, тарианы үлдэгдэл илрүүлэх/ тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2022	Малын эмч						Сумын засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгуулсан байгаа. Одоогоор төхөөрөмжтэй болоогүй. Төсөвт байгуулгын мах, сүүг улиралд нэг удаа аймгийн мал эмнэлэгийн лабораторт хүргүүлэн шинжлүүлэн шаардлагатай арга хэмжээ авч ажиллаж байна.	100
Зорилт 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулна.	1	Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, бордоо, техникийн дэмжлэгт хамруулан, дотоодын хэрэгцээний үр тарианы 60, төмс, хүнсний ногооны 70 хувийг тус тус хангана.	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг						Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрээн аваад байна. Мөн 400кг төмсний үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч 4 багийн иргэдэд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар 40кг төл сонгины үр, сормис, байцаа, лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж үрийг авчран өрхүүдэд тараан ажилласан.	70
	2	Сумдын атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн, отор нүүдлийг багасгаж, сумын өвс, тэжээлийн	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг						Сумын хэмжээнд нийт 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрээн аваад байна. Мөн 400кг төмсний үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан авч 4 багийн иргэдэд тараан өгч ажилласан. Мөн аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар 40кг төл сонгины үр, сормис, байцаа,	100

		аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.								лууван, гар манжин, хүрэн манжингийн үрийн захиалга хүргүүлж үрийг авчран өрхүүдэд тараан ажилласан. Сумын хэмжээнд нийт 300 га-д рапс, 100 га-д ногоон тэжээл тариалсанаас одоогоор ургац хураалт дөнгөж эхлээд явж байна. Рапсныхаа 150 га-д ангилан ялгалт хийсэн байна. 200 шуудай тэжээлийн үрийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ав сумын хэмжээнд нийт 110 өрхөд тараан өгч ажилласан. 5 тн ногоон тэжээлийг хүрээн аваад байна.	
Зорилт 4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1	Хүн амын хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах замаар шимт, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулна.	2021 - 2024	Хөдөө аж ахуйн тасаг, Жду						Хүнсний аюулгүй байдал, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний салбарын мэдээллийн сан бүрдүүлэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим системд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 дэлгүүр болон гал тогоо бүхий 4 газар бүртгүүлсэн. Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, зохион байгуулан Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийн сан шинээр үүсгэн ажиллаж байна. Худалдаа үйлчилгээний-7, Ахуйн үйлчилгээний-5, Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл-2, Оедол-1, Үсчин-1, Сур суран эдлэл-8, Нэхий эдлэл-5, Сүү, сүүн бүтээгдэхүүн-15, Дугуй засвар-2, Блок үйлдвэрлэл-1, Бичиг хэрэг-1, тогтмол үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуй нэгж компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт 1 удаа зохион байгуулж ажиллаа. Мөн гарааны	100

										бизнес эрхлэхтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг тухай бүр нь таниулан ажиллаж байна. 7 хоног бүрийн 1 дэх өдрийн 12 цагаас өмнө Алтан жолоо хүлэг ххк, Баян үйлст хайрхан ххк, Дөрвөн хайрхан ххк, дэлгүүрүүдээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүниий нөөцийн мэдээг авч нэгтгэн хүн амын хүнсний хангамжийн хоногийн нөөцийн тооцоог хийж Хүнс хөдөө аж ахуйн газарт 1 өдрийн 14 цагаас өмнө программд оруулан мэдээллийг хугацаанд хүргэн ажиллаж байна.	
Бүлгийн дүн										**82,5%**	
2.5. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа											
Зорилт 2. Эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой орон нутгийн дэд бүтцийг бий болгож, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	1	Сумдын төвийн доторх хатуу хучилттай авто замын сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн, Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэлийг хийнэ.	2020 - 2024 он	ЗДТГ дарга						Сумын төвөөс засмал зам хүртлэх хатуу хучилттай засмал зам тавьх зураг төсвийг улсын төсвийн хөрөнгөөр хийлгээд байна. Суман доторхи 2,7 км засмал зам тавих зураг төсвийг 18,0 сая төгрөгийн хөрөнгөөр хийлгээд байна. орон нутгийн төсвийн хөрнөгөөр ын 2022 онд сумын төвийн замыг 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр засварийн ажлыг хийж гүйцэтгээд байна.	70
